



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 95,352,238.00 (ерэн таван сая гурван зуун тавин хоёр мянга хоёр зуун гучин найм) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Ч.Оюунчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, эзэмшигчийг тогтоож /холбогдох сумдын Засаг даргын Тамгын газарт/ бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

13201010

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн
 60... дугаар тогтоолын хавсралт

Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Цаг уур өртөөний барилга /Баянхонгор аймаг Баянцагаан сум/	1 давхар, 99.144 м²	95,352,238.00	2020-07-29 УҚД- 2020/25
	Нийт дүн		95,352,238.00 /ерэн таван сая гурван зуун тавин хоёр мянга хоёр зуун мянга гучин найман мянга/	